

**АРХИТЕКТОР, ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН МЭРГЭЖИЛТНИЙГ
ДАВТАН СУРГАХ, МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТЫН
ЧИГ ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ**

2020 оны ⁰² дугаар
сарын ¹⁷ -ны өдөр

Дугаар: ^{2020/33}

Улаанбаатар хот

Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1, 34 дүгээр зүйлийн 34.1.3 дахь заалт, 34.2 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.7 дахь хэсэг, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн 22 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор нэг талаас Барилга, хот байгуулалтын яам /цаашид "яам" гэх/, нөгөө талаас "Монголын архитекторуудын эвлэл" төрийн бус байгууллага /цаашид "МАЭ" гэх/ харилцан тохиролцож "Барилгын салбарын архитектор, хот төлөвлөлтийн мэргэжилтнийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалтын чиг үүрэг" /цаашид "сургалтын чиг үүрэг" гэх/-ийг "Монголын архитекторуудын эвлэл" төрийн бус байгууллагаар үргэлжлүүлэн 3 /гурван/ жилийн хугацаатай гүйцэтгүүлэхээр энэ гэрээг 2020 оны 02 дугаар сарын 04-ны өдөр байгуулав.

Нэг. Барилга, хот байгуулалтын яамны эрх, үүрэг

1.1. МАЭ-ийг архитектор, хот төлөвлөлтийн мэргэжилтнийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалтын чиглэлийн үйл ажиллагаа явуулах мэргэжлийн төрийн бус байгууллага гэж үзнэ.

1.2. Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх талаарх бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, төсөл хөтөлбөр боловсруулах, хэлэлцэх, шийдвэрлэх, хэрэгжүүлэхэд МАЭ-ийн оролцоог хангаж, хамтран ажиллана.

1.3. Барилгын салбарын архитектор, хот төлөвлөлтийн мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох шалгалтын комиссыг зохион байгуулах, шалгалтын дүнг холбогдох дүрэм, журамд заасны дагуу баталгаажуулах ажлыг эрх бүхий этгээдээр гүйцэтгүүлнэ.

1.4. Яам нь МАЭ-ээс зохион байгуулж буй сургалтын үйл ажиллагааны явцыг хянаж, сургалтын чанар, стандарт болон энэ чиглэлийн хүний нөөц, санхүүгийн чадавхид эрх бүхий байгууллага, эсхүл яамны зохион байгуулалтын нэгжээр үнэлгээ хийлгэж, санал, дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулах эрхтэй.

1.5. Энэ гэрээний 3.2-т заасны дагуу гэрээг цуцлах тохиолдолд энэ тухай санал бэлтгэж, зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ.

Хоёр. "Монголын архитекторуудын эвлэл" ТББ-ын эрх, үүрэг

2.1. МАЭ нь "Төрийн бус байгууллагын дүрэм"-дээ энэ гэрээнд заасан сургалтын чиг үүргийг хэрэгжүүлэх талаар тусгасан байна.

2.2. Барилгын тухай хууль тогтоомж, бусад хууль тогтоомж, эрх зүйн акт, "Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм" болон "Архитектурын салбарын мэргэжилтнийг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох дүрэм"-ийн дагуу сургалтын чиг үүргийг энэ үйл ажиллагаагаар өөрийгөө санхүүжүүлж, хэрэгжүүлнэ.

2.3. Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог боловсронгуй болгох, сургалтын чанар, ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг боловсронгуй болгох, оновчтой зохион байгуулах талаар санал, санаачилга гаргаж, эрх хэмжээнийхээ хүрээнд хэрэгжүүлэх, бусад шаардлагатай асуудлаар яаманд санал тавьж шийдвэрлүүлж болно.

2.4. Сургалтын чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сургалтын төлөвлөгөөг олон улсын стандарт, хөгжлийн хандлага, салбарын болон мэргэжилтнүүдийн энэ чиглэлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсруулж “Салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл”-өөр жил тутам батлуулж, уг төлөвлөгөөний дагуу сургалтыг зохион байгуулна.

2.5. Сургалтын төлбөрийн хэмжээг “Салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл”-өөр жил тутам батлуулна. Сургалтын төлбөрт элсэгчийг бүртгэх, сургалтыг зохион байгуулах, шалгалт авах /мэргэшлийн зэрэг олгох мөн адил хамаарна/, дүгнэхтэй холбоотой зардал багтах бөгөөд шалгалтын зардлыг хариуцан шалгалт авах эрх бүхий этгээдэд шилжүүлэх үүрэг хүлээнэ.

2.6. МАЭ нь сургалтын орчны нөхцөл, шаардлагыг хангаж, сургалтын үйл ажиллагааг дэвшилтэт арга, аргачлал, техник технологийг нэвтрүүлэхэд анхаарч ажиллана.

2.7. Салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөлөөс өгсөн чиглэл, сургалтын төлөвлөгөөнд нийцсэн шалгалтын асуулт, тест, бодлого, загварчлал, даалгаврыг “түлхүүр”-ийн хамт боловсруулж мэдээллийн сан үүсгэж, тогтмол шинэчлэн баяжуулж, үнэн зөвийг хариуцан яам, холбогдох бусад байгууллагад өгөх үүрэгтэй.

2.8. Сургалтын чиг үүргийг хэрэгжүүлэхдээ захиалагч, хөрөнгө оруулагч, зураг төслийн байгууллага, салбарын төрийн бус байгууллага, мэргэшлийн холбоодын төлөөллийг оролцуулж, тэдгээрийг холбогдох мэдээллээр тухай бүр хангаж, ажиллана.

2.9. Гэрээний дагуу сургалтын чиг үүргийг зохион байгуулсан тухайг яаманд хагас, бүтэн жил тутамд тайлагнаж, холбогдох заавар, чиглэл авч ажиллана.

2.10. МАЭ-ээс архитектор, хот төлөвлөлтийн мэргэжилтнийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалтад оролцсон тухай гэрчилгээг суралцагчдад олгоно.

2.11. Энэ гэрээний 2.7-д заасан асуулт, тест, бодлого, даалгавар, загварчлал, “түлхүүр” нь МАЭ болон түүнд хамааралтай аливаа этгээдийн оюуны өмчид хамаарахгүй.

2.12. Зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдох баримт бичгийг архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомж, дүрмийн дагуу хөтлөж, хадгалах үүрэгтэй.

Гурав. Хариуцлага

3.1. МАЭ гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцад бусад этгээдэд хохирол учруулсан бол өөрийн хөрөнгөөр бүрэн хариуцан барагдуулна.

3.2. Дараах нөхцөлийн аль нэг нь бий болсон тохиолдолд яамны санаачилгаар гэрээг цуцалж, үүний улмаас хохирол учирсан бол хохирлыг МАЭ үл маргах журмаар хариуцан барагдуулна:

3.2.1. гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, байгалийн гамшиг, нийтийг хамарсан эмх замбараагүй байдлаас бусад шалтгаанаар төлөвлөгөөт сургалтыг зохион байгуулаагүй;

3.2.2. сургалтыг батлагдсан төлөвлөгөөний дагуу бус, түүнчлэн холбогдох бусад шаардлагыг зөрчиж зохион байгуулсан, эсхүл сургалтыг зохион байгуулах хүний нөөц, санхүүгийн чадавхгүй нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон;

3.2.3. сургалтын үйл ажиллагаанд ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл үүсгэсэн нь МАЭ-ийн үйл ажиллагаанаас хамааралтай бол;

3.2.4. хуульд тусгайлан заасан бусад нөхцөл.

3.3. Гэрээтэй холбоотой асуудлаар маргаан үүссэн бол хууль тогтоомжийн хүрээнд харилцан тохиролцон шийдвэрлэнэ. Ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол Монгол Улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Дөрөв. Бусад зүйл

4.1. Гэрээ 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдөр хүртэл 3 жилийн хугацаанд хүчинтэй.

4.2. Энэ гэрээний 4.1-т заасан хугацааг сунгах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах бол саналаа нөгөө талд 14-өөс доошгүй хоногийн өмнө албан бичгээр мэдэгдэнэ.

4.3. Энэхүү гэрээний нэгдүгээр хавсралтаар баталсан "Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг зорион байгуулах чиг үүргийг гүйцэтгүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө" болон хоёрдугаар хавсралтаар баталсан чиг үүргийг гүйцэтгүүлэх уг ажлын төсөв нь гэрээний салшгүй хэсэг байна.


4.4. Энэ гэрээг 3 хувь үйлдсэн бөгөөд яам 2, МАЭ 1 хувийг тус тус хадгална.

4.5. Гэрээний биелэлтийг хагас, бүтэн жил тутам дүгнэж ажиллана.


4.6. Гэрээний хугацаа дууссанаар гэрээг цуцлах санал гараагүй нөхцөлд талууд энэ гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гэрээний хугацаа сунгах, шинээр гэрээ байгуулах хүртэл хэвээр үргэлжилнэ.

Гэрээ байгуулсан:

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

 С.МАГНАЙСҮРЭН

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМНЫ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

 Д.БАЯРСАЙХАН

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМНЫ ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН
ХАРИЛЦААНЫ БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ
ГАЗРЫН ДАРГА


 Б.ГҮНБОЛД

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Засгийн газрын XII байр, Барилгачдын
талбай-3, Улаанбаатар-15170
E-майл: info@msud.gov.mn
http://www.msud.gov.mn

"МОНГОЛЫН АРХИТЕКТОРУУДЫН
ЭВЛЭЛ"-ИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ

 Э.ХҮРЭЛБААТАР

"МОНГОЛЫН АРХИТЕКТОРУУДЫН
ЭВЛЭЛ"-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

 Т.ГАНЗОРИГ

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 8 дугаар
хороо, Болгарын гудамж- 27 тоот
Улаанбаатар-14191
E-майл: uma.org.mn@gmail.com
www.uma.org.mn

Архитектур, хот төлөвлөлтийн мэргэжилтэнийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах чиг үүргийг гүйцэтгүүлэх гэрээний нэгдүгээр хавсралт

"МОНГОЛЫН АРХИТЕКТОРУУДЫН ЭВЛЭЛ" ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН БАРИЛГЫН САЛБАРЫН АРХИТЕКТОР
ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН МЭРГЭЖИЛТНИЙГ ДАВТАН СУРГАХ, МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ
СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ 2020-2023 ОН ХҮРТЭЛХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ (Бодлогын уялдаа: хууль тогтоомж, хөтөлбөр) | Арга хэмжээний шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа) | Суурь түвшин /2019 он/ | Хүрэх түвшин /2020 он/ | Хүрэх түвшин /2021 он/ | Хүрэх түвшин /2022 он/ | Хариуцах албан тушаалтан/ албан хаагч |
|--|--|---|---|---|---|---------------------------------------|
| | | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| <p>Нэг. Инженер, техникийн мэргэжилтнүүдийн мэргэжлийг тасралтгүй дээшлүүлэх сургалтын болон үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох хүрээнд (Төрөөс барилгын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө-6.3.)</p> <p>1.1. Барилгын тухай хууль тогтоомж, бусад хууль тогтоомж, эрх зүйн акт, "Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм" болон "Архитектурын салбарын мэргэжилтнийг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох дүрэм"-ийн дагуу сургалтыг зохион байгуулах, хэрэгжүүлэх.</p> | <p>Анаар. шалгуур үзүүлэлт: Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө нь ИТА-ны мэдлэг чадварыг дээшлүүлж, олон улсын түвшинд хүргэхэд чиглэсэн байх; Зах зээлийн мэргэшлийн эрэлтэд нийцсэн байх. Тоо хэмжээ: сургалт -24-өөс доошгүй Хугацаа: 2020-2023 он хүртэл</p> | <p>10 удаагийн сургалтад 150 мэргэжилтэн хамрагдсан. Үүнээс: Зөвлөх архитектор-30 Мэргэшсэн архитектор-112 Мэргэшсэн эдийн засагч- 8</p> | <p>8 удаагийн сургалт зохион байгуулсан байна. 80-аас доошгүй мэргэжилтэн хамрагдана. Үүнээс: Зөвлөх архитектор-10 Мэргэшсэн архитектор-65 Мэргэшсэн эдийн засагч- 5</p> | <p>8 удаагийн сургалт зохион байгуулсан байна. 80-аас доошгүй мэргэжилтэн хамрагдана. Үүнээс: Зөвлөх архитектор-10 Мэргэшсэн архитектор-60 Мэргэшсэн эдийн засагч- 10</p> | <p>8 удаагийн сургалт зохион байгуулна. 80-аас доошгүй мэргэжилтэн хамрагдана. Үүнээс: Зөвлөх архитектор-10 Мэргэшсэн архитектор-65 Мэргэшсэн эдийн засагч- 5</p> | <p>МАЭ-ийн Ажлын алба</p> |
| <p>1.2. Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог боловсронгуй болгох, сургалтын чанар, ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг боловсронгуй болгох, оновчтой зохион байгуулах талаар санал, санаачилга гаргаж, эрх хэмжээнийхээ хэрэгжүүлэх, бусад шаардлагатай асуудлаар яаманд санал тавьж шийдвэртгүүлэх.</p> | <p>Анаар. шалгуур үзүүлэлт: холбогдох хууль тогтоомжид нийцсэн, үндэсний хөтөлбөрт хүний нөөцийн чиглэлээр тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх болон сургалтын тогтолцоо, хөтөлбөрийг хөгжингүй орны түвшинд хүргэхэд чиглэсэн байх. Тоо хэмжээ: Санал-3 Хугацаа: жилдээ</p> | <p>Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Салбарын мэргэжилтний ангилал, давтан сургах болон мэргэжлүүлэх талаар санал өгч тусгуулсан.</p> | <p>Салбарын мэргэжилтнийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог боловсронгуй болгох, олон улсын түвшинд хүргэхэд чиглэсэн 1-ээс доошгүй саналыг боловсруулан яаманд хүргүүлсэн байна.</p> | <p>Салбарын мэргэжилтнийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог боловсронгуй болгох, олон улсын түвшинд хүргэхэд чиглэсэн 1-ээс доошгүй саналыг боловсруулан яаманд хүргүүлсэн байна.</p> | <p>Салбарын мэргэжилтнийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог боловсронгуй болгох, олон улсын түвшинд хүргэхэд чиглэсэн 1-ээс доошгүй саналыг боловсруулан яаманд хүргүүлсэн байна.</p> | <p>МАЭ-ийн Ажлын алба</p> |

| | | | | | | |
|---|--|---|--|---|--|---------------------------|
| <p>1.3. Сургалтын төлөвлөгөөг олон улсын стандарт, хөгжлийн хандлага, салбарын болон мэргэжилтнүүдийн энэ чиглэлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсруулж, "Салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох срон тооны бус зөвлөл"-өөр жил тутам батлуулах.</p> | <p>Чанар, шалгуур үзүүлэлт: - Сургалтын төлөвлөгөө ИТА-ын мэдлэг чадварыг дээшлүүлэн шинэ түвшинд гаргахад чиглэсэн байх; - Сургалтын төлөвлөгөө нь олон улсын стандарт, хөгжлийн хандлага, зах зээлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байх; Тоо хэмжээ: төлөвлөгөө-3 Хугацаа: 2020-2023</p> | <p>2018 онд батлагдсан төлөвлөгөөний дагуу 10 удаагийн сургалтыг зохион байгуулж, 150 мэргэжилтэн хамрагдсан.</p> | <p>Сургалтууд нь чанарын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан, төлөвлөгөөний дагуу тухайн жилдээ зохион байгуулагдсан байна.</p> | <p>Сургалтууд нь чанарын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан, төлөвлөгөөний дагуу тухайн жилдээ зохион байгуулагдсан байна.</p> | <p>Сургалтууд нь чанарын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан, төлөвлөгөөний дагуу тухайн жилдээ зохион байгуулагдсан байна.</p> | <p>МАЗ-ийн Ажлын алба</p> |
| <p>1.4. Сургалтын орчны нөхцөл, шаардлагыг хангаж, сургалтын үйл ажиллагааг дэвшилтэт арга, аргачлал, техник технологийг нэвтрүүлэхэд анхаарч ажиллах,</p> | <p>Чанар, шалгуур үзүүлэлт: - Сургалтын орчин шаардлага хангасан байх, - Архитекторуудын мэдлэг чадварыг дээшлүүлэн шинэ түвшинд гаргахад чиглэсэн байх; - олон улсын стандарт, хөгжлийн хандлага, зах зээлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байх; Тоо хэмжээ: арга хэмжээ-3 Хугацаа: 2020-2023</p> | <p>Сургалтын байр, тоноглол, орчин нөхцөлөөр бүрэн хангагдсан. Lupton программ хангамжийн сургалтыг онлайнгаар амжилттай зохион байгуулсан.</p> | <p>Олон улсын мэргэжилтэн бэлтгэх үйл ажиллагааг нэвтрүүлж, сургалтын чанарыг дээшлүүлнэ.</p> | <p>Олон улсын мэргэжилтэн бэлтгэх үйл ажиллагааг нэвтрүүлж, сургалтын чанарыг дээшлүүлнэ.</p> | <p>Олон улсын мэргэжилтэн бэлтгэх үйл ажиллагааг нэвтрүүлж, сургалтын чанарыг дээшлүүлнэ.</p> | <p>МАЗ-ийн Ажлын алба</p> |
| <p>1.5. Салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох сургалтын төлөвлөгөөнд нийцсэн шалгалтын асуулт, тест, бодлого, загварчлал, даалгаврыг "түлхүүр"-ийн хамт боловсруулж мэдээллийн сан үүсгэх, тогтмол шинэчлэн баяжуулах.</p> | <p>Чанар, шалгуур үзүүлэлт: - Холбогдох хууль, эрх зүйн баримт бичигт нийцсэн байх, - Шинээр батлагдсан баримт бичигт нийцүүлсэн байх; - олон улсын стандарт, хөгжлийн хандлага, зах зээлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байх; Тоо хэмжээ: багц тест-3 Хугацаа: 2020-2023</p> | <p>МАЗ-ээс Ажлын хэсэг байгуулан 1 удаа шаардагдах багц тестийг боловсруулсан.</p> | <p>Шинээр батлагдсан хууль, тогтоомж болон холбогдох БНБД, дүрэм, журам, стандартад нийцүүлсэн багц тестийг шинэчлэн боловсруулж баяжуулсан байна.</p> | <p>Шинээр батлагдсан хууль, тогтоомж болон холбогдох БНБД, дүрэм, журам, стандартад нийцүүлсэн багц боловсруулж баяжуулсан байна.</p> | <p>Шинээр батлагдсан хууль, тогтоомж болон холбогдох БНБД, дүрэм, журам, стандартад нийцүүлсэн багц тестийг шинэчлэн боловсруулж баяжуулсан байна.</p> | <p>МАЗ-ийн Ажлын алба</p> |
| <p>1.6. Салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг сунгах, горилх багц бэгийн сургалтад суусан тухай гэрчилгээг хэвлүүлэх, олгох</p> | <p>Чанар, шалгуур үзүүлэлт: - "Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм" болон "Архитектурын салбарын мэргэжилтнийг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох дүрэм"-ийн дагуу</p> | <p>Нийт 355 гэрчилгээг хэвлүүлэн олгосон. Зөвлөх архитектор-76 Мэргэшсэн архитектор-263 Мэргэшсэн эдийн засагч- 16</p> | <p>Тухайн жилд 240-өөс доошгүй гэрчилгээг олгосон байна.</p> | <p>Тухайн жилд 240-өөс доошгүй гэрчилгээг олгосон байна.</p> | <p>Тухайн жилд 240-өөс доошгүй гэрчилгээг олгосон байна.</p> | <p>МАЗ-ийн Ажлын алба</p> |

| | | | | | | |
|---|---|---|--|--|--|---------------------------|
| | <p>багц багийг тооцож олгосон байх; Тоо хэмжээ: гэрчилгээ-720 доошгүй Хугацаа: 2020-2023</p> | <p>2019 оны тайланг БХБЯ-нд танилцуулсан.</p> | <p>Сургалтыг батлагдсан Төлөвлөгөөний дагуу жил бүр зохион байгуулж, холбогдох мэдээллийг тайланд дэлгэрэнгүй тусгаж, хугацаанд нь хүргүүлсэн байна.</p> | <p>Сургалтыг батлагдсан Төлөвлөгөөний дагуу жил бүр зохион байгуулж, холбогдох мэдээллийг тайланд дэлгэрэнгүй тусгаж, хугацаанд нь хүргүүлсэн байна.</p> | <p>Сургалтыг батлагдсан Төлөвлөгөөний дагуу жил бүр зохион байгуулж, холбогдох мэдээллийг тайланд дэлгэрэнгүй тусгаж, хугацаанд нь хүргүүлсэн байна.</p> | <p>МАЗ-ийн Ажлын алба</p> |
| <p>1.7. Сургалтыг зохион байгуулсан тухай тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, яаманд хүргүүлэх.</p> | <p>Чанар, шалгуур үзүүлэлт: - Гэрээний тайлагнасан байх, - Батлагдсан төлөвлөгөөний дагуу байх; Тоо хэмжээ: тайлан -6 Хугацаа: 2020-2023 Жил бүрийн II, IV улиралд,</p> | | | | | |